

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР  
“МӨНГӨН ӨВӨЛ-2024” ЦАСНЫ БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024.02.26

Дархан-Уул аймаг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн өвлийн биеийн тамир, спортыг дэмжин хөгжүүлэх тухай 27 дугаар Зарлиг, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Биеийн тамир, спортын газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 08 тоот “Мөнгөн өвөл-2024” цасны баярыг зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын дэргэдэх Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл нь 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Соёлын салбарын ажилтан, албан хаагчдын дунд “Мөнгөн өвөл-2024” цасны баярын үйл ажиллагааг Орхон сумын “Цагаан Нуур”-т зохион байгууллаа.

Тус баярын бэлтгэл ажлын хүрээнд удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг тус тус боловсруулж аймгийн Соёл, урлагийн газрын даргаар батлуулсан.

Бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу Дархан-Уул аймгийн Залуучуудын зөвлөлийн тэргүүн, тэргүүлэгч нар тус тусынхаа бэлтгэл ажилд орон оролцоог хангаж цасны баярын тэмцээний бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА  
2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

“ЦАСНЫ БАЯР”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Монгол Улсын Ерөнхийлөгчийн өвлийн биеийн тамир, спортыг дэмжин хөгжүүлэх тухай 27 дугаар Зарлиг, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Биеийн тамир, спортын газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 08 тоот “Мөнгөн өвөл-2024” цасны баярыг зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд Соёл, урлагийн нийт ажилтнууд, уран бүтээлчид, ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний бие бэлдрийг хөгжүүлэх, спортыг нэмэгдүүлэх, хамт олонч үзэл санааг нэгтгэхэд оршино.

Хоёр. Ерөнхий зохион байгуулагч

Дархан-Уул аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл

Гурав. Хугацаа, байршил:

2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 09:30 цагт, Дархан-Уул аймгийн Орхон сумын “Цагаан” нуурт

Дөрөв. Тэмцээнд оролцох байгууллага, баг

Соёл, урлагийн ажилтнууд, соёлын биет бус өвлөн уламжлагч, уран бүтээлчид зэрэг зэргтэй эмгэгтэй тусдаа сугалаагаар бүрдсэн холимог баг бүрдэнэ. Баг тус бүр мандчилгээ дэвшүүлнэ.

“Цасны баяр”-т оролцох байгууллагууд:

1. Соёл, урлагийн газар
2. Залуучууд театр
3. Аймгийн Музей
4. Төв номын сан
5. Хүүхдийн номын ордон
6. Орхон сумын Соёлын төв
7. Шарын гол сумын Соёлын төв
8. Хонгор сумын Соёлын төв
9. Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Дархан салбар
10. Нарыг хайрла “Хойд бүсийн гэрэл зурагчдын холбоо”
11. Дарханы Зураач урчуудын эвлэл
12. Дархан хотын Чөлөөт уран бүтээлчид

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА  
2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

“МӨНГӨН ӨВӨЛ-2024” ЦАСНЫ БАЯРЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажилууд	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1.	Цасны баярыг зохион байгуулах талаар соёлын байгууллагуудад чиглэл хүргүүлэх	2024.01.22	-Залуучууд театрын маркетингийн менежер Ц.Баттөмөр -Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Б.Долгормаа
2.	Бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулах	2024.01.23	-Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Б.Долгормаа
3.	Хөтөлбөр боловсруулах	2024.01.23	-Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Б.Долгормаа
4.	Цасны баярыг зохион байгуулах байршил, урьдчилан бэлтгэх	2024.01.23-2024.01.29	-Залуучууд театрын маркетингийн менежер Ц.Баттөмөр -Дарханы Зураач, урчуудын эвлэлийн тэргүүн Н.Хишигбаатар -Орхон сумын Соёлын төвийн төлөөлөгч И.Гарздорж
5.	Оролцогчдын мэдүүлгийг авах	2024.01.22-2024.01.26	-Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Б.Долгормаа
6.	Хөгжим, микрофон, техник хэрэгсэлийн бэлэн байдлыг хангах	2024.01.23-2024.01.31	-Залуучууд театрын маркетингийн менежер Ц.Баттөмөр -Залуучууд театрын дуучин Б.Соронзонболд
7.	Оролцогч байгууллагууд өдрийн хоол, халуун цайг зэрэгт тус тусдаа зохион байгуулалт хийх тухай мэдээллийг салбарын хэлбэрд хүргэх	2024.01.23-2024.01.30	-Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөл
8.	Тэмцээний шүүгчээр ажиллах	2024.02.01	-Залуучууд театрын маркетингийн менежер Ц.Баттөмөр -МСБХ-ны тэргүүн А.Амармэнд -Дарханы Зураач, урчуудын эвлэлийн тэргүүн Н.Хишигбаатар
9.	Үйл ажиллагааг баримтжуулах, видео бичлэг хийх, зураг дарах	2024.02.01	-Төв номын сангийн мэдээллийн ажилтан Х.Отгонбаяр -Хүүхдийн номын ордны номын сан-мэдээллийн ажилтан Т.Сүмбэржав
10.	Хяналтын мэдээ бэлтгэх, мэдээ өгөх, зурагт хуудас бэлтгэх, мэдээлэл нийтлэх	2024.02.02-2024.02.06	-Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Б.Долгормаа

Зураг-1. Цасны баярыг зохион байгуулах удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулсан. /2024.01.23/



**Зураг-2.** Тус баярт оролцогчдыг 6 багт хуваан түрүүлсэн багуудыг 1, 2, 3 дугаар байр эзлүүлж өргөмжлөлийн эх бэлтгэж зохион байгуулагч нарт үнэмлэх бэлтгэв. /2024.01.28/

“Мөнгөн өвөл-2024” цасны баярт Соёлын 6 байгууллага, Дарханы Зураач урчуудын эвлэл, Дархан хотын Соёл, амралтын хүрээлэн, Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч зэрэг нийт 90 гаруй ажилтан, албан хаагчид оролцлоо.



**Зураг-3.** Оролцогч байгууллагуудын логог байршуулав. /2024.02.01/

Тус өдрийн үйл ажиллагаанд 5 төрлийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулж шүүгчээр Соёлын салбарын Залуучуудын зөвлөл ажиллан багуудыг хасагдах журмаар тэмцээнийг шүүн зохион байгууллаа.

**Тэмцээний төрөл:** Даавуутай гар бөмбөг /6х6/ нь 1 багт 6 оролцогч байх тул хоёр хоёроороо даавууг барин бөмбөгөөр харилцлаа. Нэгдүгээр байранд 5 баг буюу Хар шонхор баг түрүүлсэн.



**-Олс таталт:** Багийн бүх гишүүд оролцсон бөгөөд 8 дугаар баг тэргүүн байр эзэлсэн.



**-Морин барилдаан:** Нэг багаас эрэгтэй, эмэгтэй 2 оролцогч оролцсон бөгөөд нэгдүгээр баг буюу Шандас баг тэргүүн байр эзэллээ.



**-Мөсөн боулинг:** Нэг багаас эрэгтэй, эмэгтэй 2 оролцогч оролцсон бөгөөд нэгдүгээр баг буюу Шандас баг тэргүүн байр эзэллээ.



**-Чаргатай бухиа:** Нэг багаас эрэгтэй, эмэгтэй 2 оролцогч оролцсон бөгөөд 8 дугаар баг тэргүүн байр эзэллээ.



Соёлын салбарын Залуучуудын зөвлөл нь тэмцээнийг хасагдах журмаар шүүн эхний 3 байр эзлүүлэн шалгаруулж урамшууллаа. Үүнд:

**3-р байр- “Тулгын 3 чулуу”** баг олс таталт, мөсөн боулинг, чаргатай бухиа тэмцээнүүд дээр 12 оноогоор шалгарсан.

**2-р байр- “Хар шонхор”** баг гар бөмбөг, морин барилдаан, мөсөн боулинг тэмцээнүүд дээр 14 оноогоор шалгарсан.

**1-р байр- “1-р байранд орсон байвал яах уу”** баг гар бөмбөг, морин барилдаан, олс таталт, чаргатай бухиа тэмцээнүүд дээр нийт 24 оноогоор тус тус шалгарлаа.



ТАЙЛАН БИЧСЭН: СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН *Б. Долормаа* Б.ДОЛГОРМАА

ТАЙЛАНГ ХЯНАСАН:  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА *Х.Соёл-Эрдэнэ* Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

